

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИД МАХН-ААС НЭР ДЭВШИГЧ И.ЭНХБАЯРЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Хөгжлийн төлөө бодлого Хүний төлөө зүтгэл

Монгол Улсын эдийн засаг тогтворжиж, өсөлтийн замд орлоо. Улс төрийн ардчилсан тогтолцоо зүгширч, ардчиллын үнэт зүйлс бэхжиж, иргэдийн итгэл үнэмшил, ажил амьдралын хэм хэмжээ болон төлөвшиж байна.

Монгол Улс олон улсын хамтын нийгэмлэгт бие даасан байр сууриа эзэлсэн, даяаршлын үйл явцад идэвхтэй оролцогч, ардчиллыг сэргээн тогтоосон хөгжиж буй орны тоонд зүй ёсоор багтлаа.

Монголын ард түмэн эх оронч сэтгэл, хөдөлмөр, зүтгэлийнхээ үрээр ардчилсан үйл явцын сорилт бэрхшээл, шилжилтийн хүндхэн зурвас үеийг шантралгүй туулж, улс орон маань хөгжил дэвшлийн шинэ гараан дээр ирэв.

Хөгжлийн шинэ үед монголчууд бид:

- Улсынхаа эдийн засгийн чадамж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх
- Засаг төрийнхөө ардчилсан, хариуцлагатай, хяналттай үйл ажиллагааг бэхжүүлэх
- Нийгмээ ядуурал, ажилгүйдэл, авилга, шударга бус явдлаас ангижруулах
- Иргэдээ эрүүл, аюулгүй орчинд өндөр боловсрол эзэмшиж, чинээлэг тайван амьдрах боломжоор хангах түүхэн зорилтыг шийдвэрлэх болно.

Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшигч миний бие түмэн олныхоо язгуур эрх ашиг, үндэсний эв нэгдэл, эх орныхоо нэр төр, хууль цаазыг дээдлэн эрхэмлэж, үе үеийн Төрийн тэргүүн, Ерөнхийлөгчид, төр, засгийн бодлогын залгамж, нэгдмэл чанарыг чандлан хадгалж, ард түмнийхээ бүтээлч үйл хэргийн ололт, амжилт бүхнийг бататган бэхжүүлж, хөгжлийн шинэ үеийн дуудлага, шаардлагыг нягтлан тооцож сонгуульд оролцох Мөрийн хөтөлбөрөө боловсруулан толилуулж байна.

Мөрийн хөтөлбөрийн үндсэн агуулга нь:

- *Иргэний эрх, эрх чөлөө, иргэдийн бүх талын оролцоо, хариуцлагатай төрийн байгууламжуудын хууль ёсны шүтэлцээнд түшиглэсэн ардчилсан засаглалыг бэхжүүлэх,*
- *Иргэн бүрийн бүтээлч хөдөлмөр, шударга өрсөлдөөнд үндэслэсэн, зах зээлийн болон төрийн зохицуулалтын зохист хэм хэмжээг хослосон соёлтой бизнес, хөгжлийн суурь бүтээн байгуулалтыг дэмжихэд чиглэсэн болно.*

ҮҮНИЙ ТУЛ ӨРГӨН ТОЛИЛУУЛАХ НЬ

Үндэсний эв нэгдлийг эрхэмлэн, төрийн байгууллын тогтолцооны тэнцвэртэй, хяналттай байдлыг хангаж ажиллах талаар

-Монгол улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, ард түмнийхээ эрх чөлөө, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн хамгаалж, Үндсэн хуулийг дээдлэн сахиж, Ерөнхийлөгчийн үүргийг шударгаар биелүүлнэ.

-Үндэсний эв нэгдлийг бататган бэхжүүлэх үйлст үндэстнийхээ түүх, соёлын уламжлал, ардчиллын институцүүдийн хүчин чадлыг дүүрэн ашиглаж, нийгмийн шудрага ёсны төлөвшилд ёс суртахууны үлгэр үзүүлж ажиллана.

-Монгол төрийн тэргүүний хувьд төрийн байгууллын тогтолцооны тэнцвэртэй, хяналттай байдлыг хангаж санаачилгатай, мэдрэмжтэй байх зарчим барьж ажиллана.

-Засаг төрийн байгууллагууд хууль дээдлэх, ардчилсан зарчмыг баримтлан үр ашигтай, шуурхай, хариуцлагатай ажиллах эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.

-Монголын нийгмийн улс төрийн тогтолцоог төгөлдөржүүлэх зорилтын хүрээнд ардчиллын сонгодог загвар болох Парламентат ёсыг төгөлдөржүүлэхийг дэмжинэ.

-Нийгмийн тогтвортой байдлыг бэхжүүлж, эх орныхоо хөгжлийн таатай орчин бүрдүүлэх үүднээс улс төрийн нам хүчин, төрийн болон

төрийн бус байгууллагуудын бүтээлч хамтын ажиллагааг бүх талаар дэмжинэ.

-Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд нийгмийн шударга ёсыг төлөвшүүлэх, үндэстний эрхэмсэг оршихуйг дээдлэх, ард түмний амгалан тайван аж төрөх нөхцлийг хангах чиглэлээр идэвхтэй ажиллана.

Эдийн засгийн өсөлтийг бататгаж, чадавхийг бэхжүүлэх талаар

-Макро эдийн засаг, нийгмийн гол үзүүлэлтүүдийн тэнцвэрт харьцааг сайжруулах, төсөв, санхүүгийн болон эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх боломжийг бүрэн ашиглана.

-Үндэснийхээ үйлдвэрлэл, аялал жуулчлал, жижиг, дунд бизнесийг дэмжиж олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах үндсэн дээр улс орны эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангана.

-Байгаль цаг уурын нөхцлөөс бага хамааралтай, өндөр үр ашигтай, эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн фермерүүдийг бий болгох, экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ.

-Монгол Улсын иргэд газраа өмчлөн эдийн засгийн эргэлтэнд идэвхтэй оруулж, үр ашигтай ашиглах эрх зүйн орчинг сайжруулна.

-Гадаадын хөрөнгө оруулалтыг татах, дотоодын хөрөнгө оруулалтыг урамшуулахад чиглэгдсэн хөтөлбөр, төслүүдийг санаачлан боловсруулах, гааль, татварын бодлогоор дэмжих, ивээлдээ авч хэрэгжүүлнэ.

Мэдлэг, мэдээлэл, шинэ технологи, оюуны соёлыг улс орны хөгжлийн шийдвэрлэх хүчин зүйл болгох бодлого, үйл ажиллагааны талаар

-Боловсролын тогтолцоо, стандартыг дэлхийн жишигт нийцүүлэн шинэчлэх, орчин цагийн шинжлэх ухааны өндөр мэдлэг, мэдээллийн шинэ технологи эзэмшсэн, бодит чадвартай мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд боловсролын үйлчилгээг чиглүүлнэ.

-Үндэсний шинжлэх ухааны чадамжийг бэхжүүлэн Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн хөгжлийг улс орны эдийн засаг, нийгмийн

тогтвортой өсөлтийн тулгуур хүчин зүйл болгох, шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлүүдэд түлхүү анхаарна.

-Мэдээлэл, холбооны суурь сүлжээний багтаамжийг нэмэгдүүлж, мэдээлэл харилцааны орчин үеийн технологийг төрийн үйлчилгээ, үйлдвэрлэл, худалдаа, аялал жуулчлалын салбарт эрчимтэй хөгжүүлнэ.

-Оюуны соёлын хүрээнд бүтээлч сэтгэлгээ, чөлөөт өрсөлдөөнийг дэмжих чиглэлээр соёл, урлагийн салбарын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, энэ салбар зах зээлийн харилцааны нийтлэг жишгээр хөгжих нөхцлийг бүрдүүлэн төрийн дэмжлэг, зохицуулалтыг оновчтой болгоно.

Суурь бүтээн байгуулалт, дэд бүтэц, аялал жуулчлалыг дэмжин хөгжүүлэх талаар

-“Мянганы зам”, “Эрчим хүчний нэгдсэн сүлжээ”, мэдээлэл, харилцаа холбооны хөтөлбөр зэрэг суурь бүтээн байгуулалтуудыг үргэлжлүүлэн, тэдгээрийн үр өгөөжийг нийгэм, олон түмэнд бодитой хүргэх бодлого баримтлана.

-Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд бүсийн тулгуур төвүүд, аймгийн төв, сум суурин газруудыг холбосон болон дотоод дэд бүтцийг хөгжүүлэх, хот суурин газрыг барилгажуулах, тохижуулах бодлого, үйл ажиллагааг дэмжинэ.

-Нар, салхи, ус зэрэг сэргээгдэх эрчим хүч ашиглах замаар малчин айл өрх, хөдөөгийн сум суурин газруудыг эрчим хүчээр хангах хүрээг өргөжүүлнэ.

- Том хот, суурин газруудад утаагүй түлш, хийн түлш ашиглах зэргээр утаа, тоосгүй орчин бий болгох бодлого баримтлана.

-Агаарын тээврийн үйлчилгээг өргөжүүлж, түүнд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, орон нутгийн нислэгийн зориулалт бүхий онгоцны парк шинэчлэхэд гадаадын хөрөнгө оруулалт болон хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

-Аялал жуулчлалын гол бүс нутгуудад жуулчлалын цогцолбор байгуулах, дэд бүтцийг өргөтгөх үндсэн дээр аялал жуулчлалын олон төрлийг хөгжүүлж, дотоодын аялал жуулчлалыг дэмжинэ.

Иргэд, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядууралтай тэмцэх, шударга чинээлэг нийгмийг төлөвшүүлэх бодлого, үйл ажиллагааны талаар

- Монголын эдийн засгийн өсөлтийн өнөөгийн түвшинг хадгалах бодлогыг Засгийн газарт үүрэг болгож, эдийн засгийн өсөлтөөс олсон үндэсний орлогын 50 хувийг жил бүр улс орныхоо нийгмийн салбарт зарцуулж, иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд шууд зарцуулдаг журам тогтоох хуулийн төслийг санаачлан УИХ-аар батлуулан мөрдөх ажлыг эн тэргүүн хэрэгжүүлнэ.

- Хүн амын орлогыг нэмэгдүүлэх, өрхийн амьжиргааг дэмжих, ажлын байр бий болгох чиглэлээр Улсын Их Хурал, Засгийн газрын баримталж буй бодлого, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрүүдийг тууштай дэмжинэ.

- Үндэсний үйлдвэрлэгчид, жижиг дунд бизнес эрхлэгчид, иргэд, малчид, тариаланчдын байгуулсан хоршоо, нөхөрлөлүүдэд дэмжлэг үзүүлэх замаар ажлын байраа тогтвортой хадгалах, орлогоо нэмэгдүүлэх боломжийг өргөтгөнө.

- Нийгмийн халамжийн үйлчилгээний төвлөрлийг сааруулж, нийгмийн эмзэг хэсэгт зориулан төрөөс олгож байгаа хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, энэ үндсэн дээр нэн ядуу, ядуу айл өрхийн амьжиргааг тууштай дээшлүүлнэ.

- Эрүүл мэндийн даатгалын бие даасан байдлыг хангаж, даатгалтай иргэнд үзүүлэх урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

- Нийгмийн хамгааллын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгон үйлчилгээний чанар, хүртээмжийг нь нэмэгдүүлж, нийгмийн эмзэг бүлэгт чиглэсэн хангамж үйлчилгээг сайжруулна.

Ардчилсан засаглал, нутгийн өөрөө удирдах ёсыг бэхжүүлж, эрх зүйн шинэтгэлийг эрчимжүүлэх талаар

- Иргэд сонгогчиддоо ил тод мэдээлж тайлагнадаг, харилцан хариуцлага хүлээж, хяналт тавьдаг ардчилсан засаглалыг бэхжүүлэх хүрээнд Улсын Их Хурал, Засгийн газрын үйл ажиллагааг дэмжих бодлого баримтлана.

-Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарь, түүний удирдлагыг боловсронгуй болгох талаар Улсын Их Хурал, Засгийн газрын бодлого, үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

-Нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослох Үндсэн хуулийн үзэл баримтлалын хүрээнд өөрөө удирдах ёсыг бэхжүүлж, иргэний нийгмийн болон иргэдийн оролцоог дэмжинэ.

-Төрийн албыг мэргэшүүлэх, чадваржуулах үүднээс төрийн албан хаагчдын сонгон шалгаруулах тогтолцоог төгөлдөржүүлж, төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулна.

-Шүүх эрх мэдлийн байгууллага, шүүгчдийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгож, тэдний хүртээмжтэй, шударга мэдрэмжтэй ажиллах нөхцлийг бүрдүүлж, шүүгчийн ёс зүйн байдалд хяналт тавих, зөрчлийг илрүүлж арилгах тогтолцоог бэхжүүлж, боловсронгуй болгоно.

-Гэмт явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй иж бүрэн механизм бүрдүүлэх чиглэлээр засаг, төрийн болон төрийн бус байгууллагуудын бодлого, үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

-Нийгмийн дэг журмыг бэхжүүлж, сахилга, хариуцлагыг сайжруулах, авилга, архидалт зэрэг нийгмийн гаж үзэгдэлтэй хуулийн хүрээнд эвлэршгүй тэмцэнэ.

-Нийгмийг удирдах үйл явцад төрийн бус байгууллага (ТББ), иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр санаачлагатай ажиллана.

Гадаад харилцааг хөгжүүлэх, үндэсний аюулгүй байдлыг хангах, эх оронч үзлийг төлөвшүүлэх талаар

-Монгол Улсын гадаад бодлогын залгамж чанар, нэгдмэл байдлыг хадгалан үндэсний язгуур эрх ашгийг эрхэмлэн Монгол Улсын аюулгүй байдал, тогтвортой хөгжилд таатай гадаад орчин бүрдүүлэхэд чиглэсэн олон тулгуурт, нээлттэй, бие даасан, идэвхтэй гадаад бодлого явуулна.